

“Өмнөх амьдралдаа би монгол хүн байсан юм болов уу”

Э.ОТГОНБАЯР

Зураач, урлаг судлаач

Миний бие Герман улсад ирээд өдөр бүр хэлний дамжаанд явах, цагийн ажил хийх гэхчлэн гадаадын бусад оюутны адил тун завгүй байлаа. Одоогоос 18 жилийн өмнө анх 2006 онд Францаас Грассэт Меланигийн англи хэлээр бичсэн цахим шууданг хүлээн аваад ихэд баярлаж билээ. Тэрбээр миний эх нутагтаа байхдаа зурсан монгол болон бурхны зургууд, “Монголын нууц товчоог монгол зургийн аргаар” номын ажлуудыг интернэт хуудаснаас минь олж үзээд надтай холбогдсон нь энэ. Германы урлагийн их сургуульд оюутан болохоор хичээж буй, Барууны урлагийн ертөнцөд танилын хүрээ нь өргөжөөгүй залуу уран бүтээлч миний хувьд энэ нь тухайн үедээ маш их урам хайрласан холбоо байсан юм.

Мелани нь 2005 онд Парис хотын Луврын музейн хажууханд орших Дорно дахины үндэсний хэл, соёл иргэншлийн хүрээлэнд (INALCO) монгол хэл болон соёл иргэншлийн судлан суралцаж эхэлжээ. Тэр үед монгол судлаачин ганц багш Жак Легранд нь Дорно дахины хэлний хүрээлэнгийн ерөнхийлөгчөөр ажиллаж байсан аж. Жак Легранд бол ЮНЕСКО-гийн Нүүдэлчдийн судлаачын хүрээлэнгийн Монгол дахь ерөнхийлөгч юм.

Мелани монгол хэл шамдан суралцахын зэрэгцээ хүн төрөлхтөн түүх соёлоо үлгэр, домог, дуу бүтээлээр хэрхэн дамжуулан өвлүүлж ирснийг эртний самичуудын аман зохиолоор жишээлэн судлах явцдаа Монголын зураасан зураг, модон бар, барлах урлагтай холбогдон, татагджээ. Монгол хэл, урлаг, соёлыг судлахын тулд хоёр өөр төрлийн бичиг үсэг сурах шаардлагатай тулгарав. Шинэ цагийн кирилл бичиг, уламжлалт уйгуржин монгол бичгийг нэг дор харьцуулан үзэж, удашгүй төвөггүй уншиж, бичдэг болсноор түүний хувьд эртний болон шинэ цагийн урлаг, соёлын талаар судлах боломж нээгдсэн юм. Тэрбээр монголоос гадна төвдөөр уншиж бичдэг. Монгол болон Азийн урлаг судлалыг сонирхдогос үүдэн манай улсад зочлох мөрөөдлөө биелүүлэхээр 2006 онд бэлтгэлээ базааж явах үедээ Мелани миний уран бүтээлийн талаар анх мэдээлэл авсан юм билээ.

Монголд зочилсон анхны аялал нь түүний амьдралын замналыг тэр чигт нь өөрчилсөн гэж болно. Учир нь Монголд ирсэн эхний өдрөөс л Меланид бүх зүйл тун дотно санагдаж, харь оронд байгаа мэт сэтгэгдэл огт төрөөгүй талаар тэрбээр өгүүлсэн. Түүнчлэн учирсан хүн бүр элгэмсүү санагдаж, монголчуудтай маш хурдан ойлголцож, олон сайхан найзтай болж амжжээ. Дараагийн төрөл, төрөөр гэдэгт итгэдэггүй, энэ талаар бодож ч байгаагүй тэрбээр “Өмнөх амьдралдаа би монгол хүн байсан юм болов уу” гэсэн бодол, мэдрэмжүүд төрж хааяа өөрийн эрхгүй уйлмаар, чанга чанга инээмээр, монголоор дуулаар болно. Ингэж хүний нутагт өөриймсөх сэтгэлээ гайхаад үл барна. Сар гаруйн хугацаанд Улаанбаатарт амьдарч, хэлний дадлага хийн Монгол оронд гүнзгий татагдсан Мелани Парис руугаа буцлаа.

Тэрбээр “Хоёр хүүхэд минь ойлгохгүй байсан ч өдөр бүр монгол хэлээр уран зохиол, үлгэр домгийн чанга дуугаар уншиж өгөөд, дараа нь орчуулан ярьдаг байсан. Ингэж монголоор уншиж, ярих “ажил” минь хэдэн жил үргэлжилсэн. Үүний нөлөөгөөр удалгүй охин Луи-Касандра минь монгол дуу дуулж, монголоор ойр зуурын юмыг төвөггүй ярьдаг болсон” хэмээн дурсан ярьсан юм. Тэдний өдөр тутмын амьдралд Монголын уран зохиолын талаарх яриа өрнөдөг нь нэгэн хэвшил болон хувирсан аж. Хүүхдүүд нь унтахынхаа өмнө сонсох дуртай монгол үлгэрүүдийг франц хүүхдүүдэд зориулан орчуулахыг ээждээ санал болгосон юм билээ. Үүнээс улбаалан Мелани Монголын тал нутагт нүүдэлчдийн номын сангаараа алдартай, зохиолч Ж.Дашдондог (Төрийн шагналт) гуайтай уулзан зөвлөгөө авч, түүний номуудаас албан ёсоор орчуулах болсон байна. Мелани монгол бичгийн хичээлд өөрийгөө зориулж, тодорхой ур чадвар эзэмшихийн тулд алсын зайнаас сургалтад хам-



Мелани Монголын зураач, уран бүтээлчдийг дэлхийд таниулах том зорилготой бөгөөд эхний ээлжид Э.Отгонбаярын үзэсгэлэнг Францад нээгээд байна

Гэрэл зургийг ДЭНИ ЧАРРИЕ

рагдан, дадлага хийж, мэргэжлийнхээ ажлын хажуугаар Монголын түүх, утга зохиол, урлагийн салбарыг судалж, орчуулсаар багагүй хугацаа өнгөрөв. Энэ үед Парис хотод амьдардаг монголчуудтай холбоотой байж, ЕСЯ-аар ойрхон орж, гардаг болжээ. Түүнд монгол хэл заасан хүмүүсийн нэг нь тухайн үед Парис хотод амьдарч байсан З.Түмэнжаргал (Соёлын гавьяат зүтгэлтэн). Түүнийг Мелани “багш” хэмээн хүндлэн дурсдаг юм.

Грассэт Мелани 1990-ээд оны үед гүн ухааны чиглэлээр суралцаж байхдаа Францын Нант хотын урлагийн галерейд ажилласан нь түүнийг орчин үеийн урлагт “уруу” татсан гэдэг. Тэрбээр Францын зохиолч, кино найруулагч Маргерит Дурасын тухай уран зохиол, социологийн чиглэлээр магистрын зэрэг хамгаалсны зэрэгцээ хэд хэдэн шүүмж нийтлэл бичиж хэвлүүлсэн байна. 2000 онд Парисын VIII их сургуулийн докторантад “Урлаг ба интернэт” сэдвээр судалгааны ажлаа төвлөрүүлж дөрвөн жил суралцажээ. Энэ хугацаанд урлагт үзүүлэх интернэтийн нөлөөг прогаммчлал, дижитал урлагийн бүтээлийн олон улсын зохиогчийн эрх, хууль, эрх зүйн байдал түүнчлэн даяарчлал, интернэт мэдээлэл технологийн хурдтай хөгжлийн шинэ үед урлагийн байгууллагууд, музейн шинэчлэл орон зай “виртуал үзэсгэлэн”, “интернэт музей” гэсэн ойлголтод анхаарлаа түлхүү хандуулжээ. Өнөө үед энэ сэдвэр түүгэмэл ойлголт хэдий ч 2000 оны эхэн үед алсын зайнаас шинэчлэл зүйл байсан юм. Парисын урлагийн мэдээний “Art press”, “ViaFrance” агентлагт редактороор ажиллаж байсан Мелани интернэт мэдээлэл зүйн шинэчлэл эрх үе ирж буйг дурснаас түрүүлэн онцлон харж чадсан урлаг судлаачдын нэг. Мэдээлэл технологийн шинэ орон зайд тэрбээр соёлын салбарын урсгалыг дагаж өөрийгөө өөрчлөх шаардлагатай болсон бөгөөд виртуал бүтээлийг урлаг хэмээн хүлээн зөвшөөрөөд, албан ёсоор худалдан авч, цуглуулж эхэлсэн “Fondation cartier” болон эл төрлийн бүтээлийн дуудлага худалдааг түүчээлэн зохион байгуулсан Францын анхны байгууллага “Cocoon de Saint Cyr”, энэ сэдвийг хөндсөн анхны онолч судлаач Пьер Леви, мөн нэр бүхий уран бүтээлчидтэй тогтмол холбоотой байж, жилийн турш ярилцлага хийж, их, дээд сургуулиудад илтгэл, лекц, семинар зохион байгуулдаг байжээ.

Монголын урлагийг Франц болон Баруунд таниулан, сурталчлах үзэсгэлэн зохион байгуулах хүсэлдээ автаж тэрбээр 2006 оноос Францын хэд хэдэн музейг танилцуулах уулзалт хийсэн ч тодорхой амжилтад хүрэхгүй л байлаа. Учир нь франц хүмүүс Монголын урлагийн талаар тун бага ойлголттой. Урлаг, соёл гэхээс илүүтэй гар урлал, гоёл чимэглэлийн талаас хүлээн авч, голчлон бөө мөргөлийнх нь талаар сонирхон асуудаг байжээ. Тэр үеийг хүртэл Монголын уран бүтээлийн үзэсгэлэн Францын хэдхэн музейд тун цөөхөн гарсан байлаа. Хамгийн анх 1979 онд Вадим Элисеф, Ален Дежак нарын ивээл дор “Монголын орчин үеийн усан будгийн зургууд” үзэсгэлэн, 1993 онд “Тимет” музейд XVII зууны уран барималт Өндөр гэгээн Занабазарын бүтээлүүд, 2004 онд орчин үеийн зураач Ш.Чимэддорж, Р.Лхагварэнцэн нарын хамтын үзэсгэлэнг Сернушийн музейд буюу Чантллын цайз дахь амьд морины музейд зохион байгуулсан байна. Барууны оронд уран бүтээлч

хүний бие даасан үзэсгэлэнг бүхэл бүтэн музейд гаргах нь асар их хүндлэл юм.

Олон жил цахимаар холбоо харилцаатай байсан Мелани бид хоёр 2023 оны есдүгээр сард анх уулзлаа. Түүний гэр жижиг хэмжээний монгол номын сан гэмээр арвин ном бүтээл, цуглуулгатай, тэдгээрийн дийлэнх уйгуржин бичгээр хэвлэгдсэн нь нэн сонирхолтой. Над шиг “хуучин” монгол бичигт маруухан хүнд ичмээр байсныг нуухгүй. Бидний зарим нь эх хэлээ үл ойлгох үр хүүхэдтэйгээ харийн хэлээр хазгай муруй ярьж байхад харь үндэстний хүн эх монгол хэлийг минь сурч хүүхдүүдээ зааж байгааг харахад юу эс бодогдох билээ. Монголоос Франц руу ном авчрахад хугацаа урт, овор, жин ихтэй учир зардал өндөр. Тэрбээр судалж, мэдэхийн төлөө ямар их хөдөлмөр, мөнгө зарцуулж ийм олон ном авахаар нь ойлгомжтой, өөрийн эрхгүй бахархал сэтгэл төрсөн. Мелани намайг шар тостой сүүтэй цайгаар дайж, монгол шүлэг цээжээр уншив. Мөн агуу Б.Ринченгийн зохиолоос тунчиг яруу уншсан. Бид Монголын тухай ярилцаж суутал энэхүү франц эрдэмтэн бүсгүй “Миний хайртай Ш.Чоймаа багш бурхан болчихсон” хэмээн үйлж билээ.

Мелани Атлантын далайн эрэгт орших орчин үеийн урлагийн “Боеш” музейн захирлаар томилогдон ажилдаа орсон анхны өдрөө миний үзэсгэлэнг гаргах талаар хотын захиргаа болон музейн ажилтнуудад танилцуулсан аж. Түүний саналыг ч цааргалахгүй хүлээн авч, бэлтгэл ажил өрнөжээ. Ташрамд өгүүлэхэд, музейд зохион байгуулах үзэсгэлэн, арга хэмжээнүүд олон жилийн өмнөөс төлөвлөдөг, басхүү адармаатай ажил юм. “Боеш” музейг жилд дөрвөн үзэсгэлэн зохион байгуулдаг. Үзэсгэлэн бүрийг нэг улирлын турш толилуулдаг тул үзэгчдийг уйдаахааргүй сонирхолтой байх, амжилттай яваа уран

бүтээлч, бүтээл байх зэргээр тун нарийн судалж, хэлэлцдэг юм гэсэн.

2024 оныг хүртэл монгол уран бүтээлчийн бие даасан, ганцаарчилсан үзэсгэлэн Франц улсын музейнүүдэд гарч байгаагүй аж. Тэгвэл энэ оны нэгдүгээр сарын 12-нд Меланигийн курааторлаг зохион байгуулсан “ОТГО: Эргэн харахуй уламжлалаас орчин үед” нэртэй бүрэн хэмжээний үзэсгэлэн нээгдэв. Гурван сарын хугацаанд “Боеш” музейд толилуулах уг үзэсгэлэн миний 1998-2024 онд “төрсөн” бүтээлүүдээс сонгон шалгаруулж аль болох олон талаас нь тухайн цаг үеийг төлөөлж чадахаар 60 зураг болон “Монголын нууц товчоо монгол зургийн аргаар” номын танилцуулга бүхий франц хэлээрх орчуулгууд багтсан. Энэхүү үйл явдлыг “Монголын дүрслэх урлагт шинэ түүхийн хуудас нээж байна” хэмээн тодотгосон нь жирийн нэгэн уран бүтээлч миний хувьд том бахархал билээ. Энэхүү үзэсгэлэн бол 2006 оноос эхэлсэн судалгаа шинжилгээ, бэлтгэл ажлын үр дүн гэдгийг дурдах нь зүйтэй. Үзэсгэлэн гаргана гэдэг хэдэн зураг өлгөөд болчихдог хялбар ажил биш гэдгийг энэхүү судалгаа, урт хугацаа харуулах буй за.

Францад зохион байгуулж буй эл арга хэмжээний тухай өгүүлэх энэ ташрамд Нант хотын Бретанийн гүнгийн ордон буюу Түүхийн музейд толилуулж буй “Чингис хаан: Монголчууд дэлхийг өөрчилсөн нь” үзэсгэлэнгийн талаар товчхон боловч дурдахыг хүслээ. Учир нь би бол Монгол нутгийн хүн, монгол уран бүтээлч. Тиймээс монголчуудын бахархал болсон эл үзэсгэлэнгийн талаар байнга чих тавин, сонин хэвлэлүүдээс шинэ мэдээлэл уншиж байна. Үүнээс гадна “Боеш” музейд өдгөө гарч буй миний үзэсгэлэнг Нант хотын Түүхийн музейн албан ёсны хөтөлбөрт багтааж тус ордон руу нүүлгэх бөгөөд дөрөвдүгээр сарын 5-28-нд үзэгчдийн хүртээл болох юм.

Тавдугаар сарын 5 хүртэл үргэлжлэх “Чингис хаан: Монголчууд дэлхийг өөрчилсөн нь” үзэсгэлэнг зорин ирэх гадаад, дотоодын үзэгч хэдэн мянгаар тоологдож байна. Зарим өдөр 1-2 цаг гадаа хүйтэнд дугаарласны эцэст танхимд орж байгаа нь хэр эрэлтгүйг харуулах ганцхан жишээ юм. 300 000 мянган хүн амтай Нант хотод зохион байгуулж буй үзэсгэлэнг одоогийн байдлаар давхардсан тоогоор 200 мянга орчим хүн сонирхон монголчууд дэлхийг хэрхэн өөрчилсөн түүхийн талаар мэдэж авсан гэдэг албан ёсны мэдээ буй. Хүн амынх нь талаас илүү хувьтай тэндэх жуулчин Нантад очсон гэхээр тэнд аялал жуулчлалыг хөгжүүлэхэд Чингис хаан их үүрэг гүйцэтгэж буйг албаныхан нь ч дохон тэмдэглэсэн нь бас л сонихон.

The Nature Conservancy
Mongolia

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАР ОРОН НУТГИЙН БИЧИЛ САНХҮҮГИЙН ЗӨВЛӨХ

Дэ Нэйче Консерванси (The Nature Conservancy - TNC) олон улсын байгаль хамгаалах байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газраас хэрэгжүүлж буй **“Нутгийн иргэдийн манлайлсан байгаль хамгаалал”** (НИМБХ) төсөл нь Ховд болон Хэнтий аймгуудад зөвлөх үйлчилгээ үзүүлэх Бичил санхүүгийн зөвлөхийн сонгон шалгаруулалтыг зарлаж байна. **Бичил санхүүгийн зөвлөх** нь өөрийн аймагт байрлан, НИМБХ төслийн зорилтот сумдуудад үйлчилгээ үзүүлнэ.

Ажлын байрны статус: Гэрээт зөвлөх**Зөвлөх үйлчилгээний хугацаа:** Энэхүү зөвлөх үйлчилгээ нь гурван сарын хугацаанд үргэлжлэх бөгөөд төслийн санхүүжилт болон үйлчилгээний цар хүрээнээс хамааран цаашид сунгагдах боломжтой байна.**Бичил санхүүгийн зөвлөхийн гүйцэтгэх үүрэг:**

- Нөхөрлөлд хэрэгжүүлэх дундын сан хөгжүүлэлт, хуримтлалын хөтөлбөрийг зохион байгуулах, чадавхижуулах хэрэгцээг тодорхойлох, холбогдох сургалтуудыг хийх, гүйцэтгэлд мониторинг хийх, шаардлагатай арга хэмжээг авах;
- Зээлийн болон хадгаламжийн үйлчилгээнүүдийг тодорхойлох, шаардлагатай аргачлал, зөвлөмж, гарын авлага боловсруулах;
- Малчид болон иргэдэд санхүүгийн боловсрол олгох, зардлыг ухаалаг болгох, хэмнэлт хуримтлалтад сургах, МАА-г үр ашигтай удирдах г.м сургалтуудын модуль, аргачлал, гарын авлага боловсруулах, сургалтуудыг хийх, сурталчилгааны материалууд, аргачлалыг боловсруулах;
- Нөхөрлөлийн удирдлага, засаглалыг идэвхжүүлэх, чадавхижуулахад шаардлагатай сургалт, зөвлөмжөөр хангах;
- ХЗХ, хуримтлалын бүлэг г.м нутгийн иргэдийн удирдлага өмчлөл бүхий албан болон албан бус бүтэцтэй харилцан ашигтай хамтран ажиллах арга хэлбэрийг тодорхойлох, хамтын ажиллагааг уялдуулан удирдах, мониторинг хийх;
- Малчдын санхүүгийн нөхцөл байдалд гол нөлөөтэй МАА-н үйл ажиллагаанд шинжилгээ хийх, хандлагыг өөрчлөх арга хэлбэрүүдийг тодорхойлох, тооцоолууд хийх, турших, нэвтрүүлэх, дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах;
- TNC байгууллага, НИМБХ төслийн удирдлага ажилтнууд, зөвлөхүүд, тухайн сумын Орон нутгийн зохицуулагчтай үйл ажиллагаагаа нягт уялдуулан, дэмжлэг үзүүлэн ажиллах;
- Төслийн холбогдох мэргэжилтэн, зөвлөхүүдээс үүрэг болгосон бусад ажлыг гүйцэтгэнэ.

Тавигдах шаардлага:

- Бизнес, санхүү, эдийн засаг болон холбогдох чиглэлээр бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй, тус чиглэлээр гурван жилээс доошгүй ажилласан туршлагатай байх.
- Ховд, Хэнтий аймгуудад байнга оршин суудаг байх.
- Аливаад бүтээлч санаачилгатай, асуудлыг шийдвэрлэх, багаар ажиллах, шийдвэр гаргах, асуудал дун шинжилгээ хийх, зохион байгуулах мэдлэг, чадвар, туршлагатай.
- Нутгийн иргэд, малчидтай хамтарч ажиллаж байсан туршлагатай байх.
- Шаардлагатай тохиолдолд бусад аймгууд болон Улаанбаатар хотод томилолтоор ажиллах боломжтой байх.

Материал ирүүлэх хугацаа: 2024 оны 02 дугаар сарын 08-ны Пүрэв гаригийн 10.00 цаг хүртэл**Материал илгээх хаяг:** admin.mongolia@tnc.org**Бүрдүүлэх материал:**

- Үйлчилгээ үзүүлэх сонирхлоо илэрхийлсэн, тавигдах шаардлагад хэрхэн нийцэж буй болон өөрийн онцлог давуу талаа илэрхийлсэн өргөдөл. Өргөдөлд гүйцэтгэх ажил үүрэг нь яагаад чухал болох талаар өөрийн санал, дүгнэлтийг тусгасан байх
- CV (гүйцэтгэх ажил үүрэгтэй холбоотой туршлагаагаа дэлгэрэнгүй оруулсан байх).
- Дипломын хуулбар

Сонгон шалгаруулалт: Зөвхөн шаардлагыг хангасан хүсэлт гаргагчидтай холбогдон, сонгон шалгаруулалтыг явуулах болохыг анхаарна уу.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2024 оны 01 дүгээр сарын 31**Тендер шалгаруулалтын нэр:** Шатах тослох материал худалдан авах**Тендер шалгаруулалтын дугаар:** ХЭАНЭ/20240102004

- Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг **Шатах тослох материал худалдан авах** тухай тендер ирүүлэхийг урьж байна.
- Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ:
Дотоодын үйлдвэрээс худалдан авах бараа байгаа бол тодорхой бичих;
- Тендерийг **2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 10.00 цагаас өмнө** тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 10.30 цагт** нээнэ.
- Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: Зөвшөөрөхгүй
- Гадаадын этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендер ирүүлэх эрхтэй эсэх: Эрхгүй
- Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд хүчинтэй байхаар тендерт заана.
- Тендерийн баталгаа шаардах эсэх:** 730,521 төгрөг
Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичигт заасан үнийн дүн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.
- Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: Үгүй
- Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: Үгүй
- Сонирхогч этгээд худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалтын баримт бичигтэй үнэ төлбөргүй танилцах эрхтэй бөгөөд үйлчилгээний хураамж 50000 төгрөгийг төлснээр тендер шалгаруулалтад оролцох эрхтэй байна.

Хаяг: Монгол Улс, Хэнтий аймаг, Хэрлэн сум, 4 дүгээр баг,
Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг
Утас: 88824402
Email: emiinsan07@gmail.com